


**УЛС ТӨРИЙН ҮЙЛ ЯВЦАД ХЭВЛЭЛ
МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН НӨЛӨӨ**

ТУЛГУУР ОЙЛГОЛТ

- Олон түмнийг нийтлэл, нэвтрүүлгийн тусламжтайгаар үнэн бодитой мэдээллээр шуурхай, тогтмол хангах зорилго бүхий тогтмол хэвлэл, радио, телевиз, мэдээллийн агентлаг, баримтат кино, цахим хэвлэл зэрэг мэдээллийн сувгийг **олон нийтийн мэдээллийн хэрэгсэл** гэж нэрлэдэг.
- Маркетинг болон брэндийн зорилгодоо хүрэхийн тулд бүтээгдэхүүнээ сурталчилж, дэмжсэн контент бүтээж, нийгмийн сүлжээнүүдэд дамжуулж, түгээх интернет сурталчилгааг **Сошиал медиа** маркетинг гэнэ.
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль 1998. 8.28 нд батлагдсан

Сошиал медиа маркетинг гэж юу вэ?



ДЭЛХИЙН ХЭМЖЭЭНД СОШИАЛ МЕДИА ХЭРЭГЛЭЭ /2019 ОНЫ НЭГДҮГЭЭР САРЫН БАЙДЛААР/



Нийт хүн ам
7.676 тэрбум




Гар утас хэрэглэгчид
5.112 тэрбум



Интернэт хэрэглэгчид
4.388 тэрбум



Сошиал медиа хэрэглэгчид
3.484 тэрбум



Гар утсаар
Сошиал медиа хэрэглэгчид
3.484 тэрбум

ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ТОГТОЛЦОО


ТОГТМОЛ ХЭВЛЭЛ

РАДИО

ТЕЛЕВИЗ

МЭДЭЭЛЛИЙН АГЕНТЛАГ

БАРИМТАТ КИНО



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ҮҮРЭГ



**Мэдээлэл
олгох**



**Иргэдийг
төлөвшүүлэх**



**Хяналт,
шүүмжлэл
өргүүлэх**



**Боловсрол
олгох**



Үйл ажиллагаа 4.8 Сурах бичиг 152 хуудас

2015 оны “Ардчилсан засаглал” судалгааны дүнгээс хэвлэл, мэдээллийн хэрэгслийн улс төр, эдийн засаг, санхүүгээс хараат бус байдлын талаарх иргэдийн төсөөллийг авч үзвэл, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь улс төрөөс хараат бус байдаг гэдэгтэй судалгаанд хамрагдсан иргэдийн 42.6 хувь нь санал нийлдэггүй, 23.0 хувь нь дунд зэрэг буюу өмнөх онтой харьцуулахад тус тус 1.9 пунктээр өссөн, харин 8.3 хувь нь санал нийлдэг гэж хариулсан ба өмнөх оноос 3.5 пунктээр буурсан байна. Мөн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь эдийн засаг, санхүүгээс нэлээд хараат байна гэж иргэдийн дийлэнх үзэж байгаа нь нийт авбал зохих онооны дөнгөж тавны нэгийг авч байгаагаар илэрхийлэгдэж байна.

Эх сурвалж:http://1212.mn.Cover_2014-2015.pdf&ln=Mn

Асуулт:

1. Эх сурвалж ямар асуудлыг хөндөж байна вэ?
2. Уг асуудлын талаар өөрийн байр сууриа илэрхийлнэ үү
3. Төр засгийн зүгээс энэ асуудлыг шийдвэрлэх ямар бодлого явуулах шаардлагатай гэж үзэж байна вэ?
4. Тухайн асуудлыг шийдвэрлэхэд иргэд, улс төрийн бусад байгууллага ямар үүрэг, оролцоотой вэ?



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗАРЧИМ



01

Олон түмний дунд
үнэн зөв мэдээлэл
дамжуулах

02

Бүх нийтэд тэгш
хүртээмжийг
хуулиар хангах

03

Ард түмний дуу
хоолой болох

04

Хэвлэл мэдээллийн
ажилтнуудын эрх
ашгийг хамгаалах





Герман улс дахь “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай ойлголт, эрх зүйн зохицуулалт



- Герман Улсын Үндсэн хуулийн 5-р зүйл-д “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй”, 5.1-т **Хүн бүр үг хэлэх, аливаа зүйлийг нийтлэх, дүрслэн илэрхийлэх болон бусдад түгээх эрх чөлөөтэй, мөн түүнчлэн мэдээллийн эх сурвалжийг нээлттэй мэдэгдэх эрхтэй.**” гэж заасан
- ХБНГУ-ын 1953 оны 11-р сард Штутгарт хотод болсон олон нийтийн хүлээн авалтан дээр гомдол гаргагч буюу дээд шатны шүүгч Герман Улсын хэвлэл нийтлэлийн байгууллагын 95% нь үйлдвэрчний эвлэлтэй таарамж муутай байдаг бөгөөд ажил олгогчийнхоо хяналтанд байдаг тухай шүүмжилсэн.
- 7 хоног тутмын Де Шпигел сэтгүүл нь тус шүүгч нь коммунист талыг баригч гэсэн нийтлэлийг хэвлүүлжээ.
- Харин шүүгч Шмид нь өдөр тутмын сонинд: Де Шпигел сэтгүүл нь хүн рүү үндэслэлгүй дайрсан агуулгатай нийтлэлээ буцааж татах талаар бичсэн.



ТАЙЛБАР

1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь бусад орнуудын хувьд нийгмийн харилцааны өргөн хүрээг хамарсан ойлголт байна. Тухайлбал, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхдээ тайван бус хурц, ширүүн өнгө аястай илэрхийлж болох бөгөөд нь энэ нь олон нийтийн эрх ашгийг зөрчөөгүй байх ёстой байна.

2. Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн шүүхэд иргэний зүгээс гомдол гаргахдаа шүүхийн шийдвэр **үндсэн эрх зөрчсөн гэж хандах эрхгүй** тул Эрүүгийн хуулинд заасан Доромжлох, Гүтгэх гэмт хэрэгт шийтгүүлж буй этгээдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх зөрчигдсөн эсэх, эсхүл үнэн зөв, тохирсон хариуцлага оногдуулсан эсэхэд дүгнэлт хийх бололцоогүй байна.

3. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлсэний улмаас иргэн хохирсон бол иргэний хуулийн дагуу гэм хорыг арилгах зохицуулалтыг хэрэглэсэн нь иргэний эрхийг сэргээхэд илүү ач холбогдолтой байна.



Үйл ажиллагаа 5.9. Баримтыг уншиж, шинжилгээ хийж, асуултад хариулаарай.

2016 оны судалгаагаар Монголчууд санал бодлоо чөлөөтэй илэрхийлдэг гэж судалгаанд хамрагдагсад 49.3 оноо өгсөн нь өмнөх оноос 8.1-ээр буурсан байна. Мөн иргэдийн хэвлэл мэдээллийн байгууллагуудад итгэх итгэл Монголын үндэсний телевизэд 90, үндэсний радио, орон нутгийн телевизэд 80, хувийн телевизэд 78, өдөр тутмын хэвлэлд 68, FM радиод 60 гэсэн үнэлгээ өгсөн нь өнгөрсөн оноос 1-6 оноогоор буурсан байна.

Харин шар хэвлэлийн хувьд 34 оноо буюу өмнөх оноо 4-өөр буурсан нь шар хэвлэлд итгэдэггүй хэвээр байгааг харуулж байна. 2015 онд иргэдийн хэвлэл мэдээллийн байгууллагад итгэх итгэл 80 оноо өгсөн нь өмнөх оныхоос 6 оноогоор буурсан байна.

Асуулт

1. Энд ямар асуудал хөндөгдөж байна вэ?
2. Хэвлэл мэдээлэл иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлж байна вэ?
3. Энэ асуудлыг шийдэх төрийн бодлогын хувилбар дэвшүүлж давуу болон сул талыг тодорхойлоорой
4. Өөрийн сонгосон бодлогыг хэрхэн хэрэгжүүлэх талаар тайлбарлаарай.